

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | | |
|-------|---|----|
| 1 | Аудитын гэрчилгээ..... | 2 |
| 2 | Аудитын тайлан..... | 4 |
| 2.1 | Оршил..... | 4 |
| 2.2 | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага..... | 4 |
| 2.3 | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4 | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 6 |
| 2.6 | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал..... | 6 |
| 2.7 | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8 | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 7 |
| 2.8.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал..... | 7 |
| 2.9 | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 7 |
| 2.10 | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 8 |
| 2.11 | Шилэн дансны мэдээлэл..... | 8 |
| 2.12 | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 8 |
| 2.13 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 9 |
| 3 | Менежментийн захидал..... | 10 |
| 3.1 | Бэлэн мөнгөний орлогын талаар..... | 10 |
| 3.2 | Бараа материалын тооллогын талаар | 10 |
| 3.3 | Татварын талаар..... | 11 |
| 3.4 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар | 11 |
| 3.5 | Бэлэн мөнгөний орлогын талаар..... | 12 |
| 4 | Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан | 13 |
| 4.1 | Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан | 13 |
| 4.2 | Аудит хийгдсэн орлого үр дүнгийн тайлан | 15 |
| 4.3 | Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 17 |
| 4.4 | Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 19 |
| 4.5 | Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 20 |
| 4.6 | Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан тайлан | 22 |
| 5 | Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт..... | 23 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БШСУСЯ | Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын яам |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН
ГАЛЕРЕЙН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Б.САРАНТУЯА ТАНАА

2019.02.25 № 06/269
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монголын уран зургийн галерейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын уран зургийн галерейн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Монголын уран зургийн галерейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монголын уран зургийн галерейн захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Сарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монголын уран зургийн галерейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-ийн аудитор Б.Баяндүүрэн, аудиторын туслах Г.Цэнд-Аюуш нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монголын уран зургийн галерейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монголын уран зургийн галерейн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Монголын уран зургийн галерей нь Монголын орчин үеийн дүрслэх урлагийн бүтээлүүдийг сурталчлан таниулах, Музей түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах. гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монголын уран зургийн галерей нь Монголын орчин үеийн дүрслэх урлагийн бүтээлүүдийг олон түмэнд сурталчлан танилцуулах зорилгоор 1991 онд Дүрслэх Урлагийн Музейгээс салж бие даан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Монголын уран зургийн галерейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Музей түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үйл ажиллагаа.

Монголын уран зургийн галерейн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монголын уран зургийн галерейн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Соёлын өвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Монголын уран зургийн галерейн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтнийг татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монголын уран зургийн галерей санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн асoulous програм хангамж ашигладаг байна.

Монголын уран зургийн галерейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 1 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнгээр сонгоход материаллаг түвшин бага байсан тул төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгосон.

Монголын уран зургийн галерейн 2018 оны нийт зардал 346,062.1 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 3,460.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

| № | Шийдэл | Тоо | Дүн | /мянган төгрөг/ Тайлбар |
|---|---------------|----------|--------------|----------------------------|
| | | | | |
| 1 | Зөвлөмж өгсөн | 5 | 359.7 | |
| | Дүн | 5 | 359.7 | |

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн шинж чанартай 720.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг зардлаар бүртгэсэн. Залруулах бичилт хийгдсэн.
- Тайлант үед хамаарахгүй 22,464.4 мянган төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрсөн. Залруулах бичилт хийсэн.
- Орлого үр дүнгийн тайланд 6,086.5 мянган төгрөгийн зардлын ангиллыг буруу бүртгэсэн. Залруулах бичилт хийсэн.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Монголын уран зургийн галерейн санхүүгийн байдлын тайланд тусгагдсан хөрөнгө бодитой байгаа эсэхийг тодруулах, соёлын үнэт өвийн хадгалалт хамгаалалт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр яригдаж байгаа асуудалд анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Санхүүгийн тайланд бүртгэлтэй боловч “Их тэнгэрийн ам” төрийн тусгай хамгаалалтын газарт байрлах 34 дэсийн 34 ширхэг 95,500.0 мянган төгрөгийн уран зургийг бодитоор байгаа эсэхийг тодруулах, буцаан авах талаар байгууллагын удирдлагын Төрийн тусгай хамгаалалтын газарт 10/480, БСШУСЯ-ны сайдад А/115, Төрийн тусгай хамгаалалтын газарт 10/636, Ерөнхийлөгчийн тамгын газарт 154, УИХ-

ын тамгын газрын дарга Ц.Цолмонд 155, ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга Г.Баясгаланд 156, БСШУСЯ-ны сайдад 158 зэрэг тоот албан бичгүүдийг явуулсан. Эдгээр албан тоотын хариуд Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын А/144, БСШУСЯ-ны сайдын 7/8492, БСШУСЯ-ны сайдын 7/10148, БСШУС-ын яамны сайдын тушаал А/756 тоотуудаар ирсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

- 2009 оноос хойш үүссэн 14,211.1 мянган төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагын талаар удирдлага, нягтлан бодогч, нярав нарын удаа дараагийн албан болон албан бус оролдлогын үр дүнд 750.0 мянган төгрөгийн төлөлт хийгдсэн байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монголын уран зургийн галерейн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдон 2018 онд 311,365.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 305,125.1 мянган төгрөг байгаа нь батлагдсан төсвийг 6,240.4 мянган төгрөгөөр буюу 2 хувиар хэмнэлттэй зарцуулсан.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Монголын уран зургийн галерейн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээллэж байх үүрэгтэй.

Тус байгууллага төсвийн орлого, зарлага түүний хэмнэлт хэтрэлтийг сар бүр, 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлээгүй байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар хувь хүмүүсээс авах авлагыг барагдуулах, хандивын хөрөнгийг орлогод бүртгэх, тооллогоор дутагдсан үндсэн хөрөнгийн эзэн холбогдогчийг тодруулах, төлбөрийг барагдуулах, санхүүгийн тайланд бүртгэлтэй боловч “Их тэнгэрийн ам” төрийн тусгай хамгаалалтын газарт байрлах 34 дэсийн 34 ширхэг уран зургийг бодитоор байгаа эсэхийг тодруулах, буцаан авах зэрэг зөвлөмж өгөгдсөн. Зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

Дээрх өгөгдсөн зөвлөмжөөс хувь хүмүүсээс авах авлага барагдуулалт, “Их тэнгэрийн ам” төрийн тусгай хамгаалалтын газарт байрлах 34 дэсийн 34 ширхэг уран зургийг бодитоор байгаа эсэхийг тодруулах буцаан авах зэрэг ажил хийгдээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монголын уран зургийн галерейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монголын уран зургийн галерейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монголын уран зургийн галерейн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Бэлэн мөнгөний орлогын талаар

3.1.1. Илрүүлэлт:

Монголын уран зургийн галерей нь өөрийн үйл ажиллагааны орлого, билет, номын бэлэн мөнгөний орлогыг кассаар дамжуулахгүйгээр хурааж байгаад сард 1 удаа харилцах дансанд тушаадаг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж тайлагнана” гэж заасныг мөрдөөгүй байна. Сар бүр дунджаар 809.3 мянган төгрөг тушаадаг.

3.1.2. Эрсдэл:

Хууль тогтоомж зөрчигдөх, санхүүгийн сахилга бат алдагдах эрсдэлтэй.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Бараа материалын тооллогын талаар

3.2.1. Илрүүлэлт:

Складад байгаа хангамжийн материалаас түүвэрлэн 12 нэр төрлийн барааг тоолж үзэхэд 9 нэр төрлийн 115.5 мянган төгрөгийн ахуйн хэрэглээний бараа бүртгэлтэй байгаа тооноос илүү байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь” Анхан

шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

3.2.2. Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж, аргачлал зааврыг зөрчих, байгууллагын үр дүнг буруу тайлагнах, санхүүгийн сахилга бат алдагдах

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн заалтыг мөрдөж ажиллах, санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Татварын талаар

3.3.1 Илрүүлэлт:

Ажилчдаас суутгасан нийгмийн даатгал, эрүүл мэндийн шимтгэлийн дүнг цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан татварын тайланд дутуу тайлагнасан. Хувь хүний орлогын албан татварын 206.6 мянган төгрөгийн хөнгөлөлтийг илүү тооцсон.

3.3.2. Эрсдэл:

Холбогдох хуулийн заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллахгүй байх, татварын алданги торгууль хүлээх эрсдэлтэй .

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тайлангийн хөнгөлөлтийн тооцоог дахин хийж тайлагнах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

3.4.1. Илрүүлэлт:

Тус байгууллага төсвийн орлого, зарлага түүний хэмнэлт хэтрэлтийг сар бүр, 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлээгүй байна.

3.4.2. Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахгүй байх.

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Монголын уран зургийн галерейн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээллэж байх үүрэгтэй.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.5. Бэлэн мөнгөний орлогын талаар

3.5.1. Илрүүлэлт:

Үзвэрийн билетийн бэлэн мөнгөний орлогыг касст бүртгэдэггүй хувь хүний гар дээр хадгалдаг. Бэлэн мөнгөний тооллогоор 37.5 мянган төгрөг дутсан.

3.5.2. Эрсдэл:

Үнэн зөв байх

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох этгээдээр төлбөрийг барагдуулах.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 7 дугаар сарын 01-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|--------------------------|--------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 99,660,994.19 | 116,222,328.28 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 00.00 | 00.00 |
| 33 | АВЛАГА | 14,961,154.69 | 14,279,533.78 |
| 335 | Бусад авлага | 14,961,154.69 | 14,279,533.78 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 68,379.09 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 14,961,154.69 | 14,211,154.69 |
| 3471 | Урьдчилгаа тооцоо | 00.00 | 22,464,430.00 |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 00.00 | 22,464,430.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 84,699,839.50 | 79,478,364.50 |
| 351 | Түүхий эд материал | 1,470,000.00 | 420,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,470,000.00 | 420,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 83,229,839.50 | 79,058,364.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 24,880.00 | 505,950.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,676,757.00 | 3,574,297.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 79,528,202.50 | 74,978,117.50 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 15,265,559,548.55 | 15,268,072,416.37 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 15,265,559,548.55 | 15,268,072,416.37 |
| 391 | Газар | 00.00 | 00.00 |
| 392 | Биет хөрөнгө | 15,265,559,548.55 | 15,268,072,416.37 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 18,057,500.00 | 18,057,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -3,611,500.08 | -4,965,812.61 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 120,952,025.68 | 62,647,805.75 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -100,231,693.69 | -44,605,382.07 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 79,187,393.41 | 63,098,858.41 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -64,758,058.77 | -42,124,435.11 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 15,214,105,700.00 | 15,214,105,700.00 |
| 39217 | Ном | 1,858,182.00 | 1,858,182.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 00.00 | 00.00 |
| 39301 | Програм хангамж | 1,370,000.00 | 1,370,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,370,000.00 | -1,370,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 15,365,220,542.74 | 15,384,294,744.65 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 273,975.30 | 302,781.90 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 273,975.30 | 302,781.90 |
| 413 | Өглөг | 273,975.30 | 302,781.90 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | |
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 00.00 | 00.00 |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 00.00 | 00.00 |
| 41350 | Зээлийн хүүгийн өглөг | 00.00 | 00.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 15,364,946,567.44 | 15,383,991,962.75 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 15,364,946,567.44 | 15,383,991,962.75 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 859,650,551.83 | 859,650,551.83 |
| 51101 | Өмч: - төрийн | 859,650,551.83 | 859,650,551.83 |
| 51102 | - хувийн | 00.00 | 00.00 |
| 51103 | - хувьцаат | 00.00 | 00.00 |
| 51104 | Халаасны хувьцаа | 00.00 | 00.00 |
| 51105 | Нэмж төлөгдсөн капитал | 00.00 | 00.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 00.00 | 00.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 190,571,779.61 | 209,617,174.92 |

Монголын уран зургийн галерейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|----------|--|---------------------------------|---------------------------------|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 190,571,779.61 | 190,571,779.61 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 19,045,395.31 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 14,314,724,236.00 | 14,314,724,236.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>15,365,220,542.74</u> | <u>15,384,294,744.65</u> |

4.2 Аудит хийгдсэн орлого үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 362,887,979.15 | 365,107,511.50 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 85,496,339.15 | 39,070,911.50 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 85,496,339.15 | 39,070,911.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 81,743,339.15 | 39,070,911.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,357,000.00 | 23,022,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,906,449.40 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 58,479,889.75 | 16,048,411.50 |
| 120009 | Бусад орлого | 3,753,000.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 277,391,640.00 | 326,036,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 275,324,500.00 | 295,805,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 275,324,500.00 | 295,805,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,980,000.00 | 30,231,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,980,000.00 | 30,231,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 87,140.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 87,140.00 | |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 330,126,652.29 | 346,062,116.19 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 330,126,652.29 | 331,585,689.67 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 324,229,156.09 | 331,585,689.67 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 109,752,680.00 | 116,098,733.72 |
| 210101 | Үндсэн цалин | 100,619,380.00 | 77,610,916.72 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 15,752,465.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,133,300.00 | 16,380,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 6,355,352.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 12,537,966.00 | 15,814,693.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,537,966.00 | 12,195,511.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 632,331.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 586,203.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 146,550.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 2,254,097.50 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 126,225,000.00 | 126,225,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 126,225,000.00 | 126,225,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,518,607.80 | 14,216,019.82 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,068,230.00 | 2,366,919.96 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 1,591,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,449,997.80 | 1,465,963.32 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 686,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 545,300.00 | 859,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 21,455,080.00 | 7,246,436.54 |
| 2105 | Нормативт зардал | 418,000.00 | 1,719,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 418,000.00 | 1,719,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,210,000.00 | 5,210,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,210,000.00 | 5,210,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 497,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 497,000.00 | 00.00 |

| | | | |
|-------------|--|----------------------|----------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,748,000.00 | 35,073,580.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,748,000.00 | 31,483,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 1,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 104,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 114,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 2,371,580.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,321,902.29 | 17,228,662.18 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,192,449.40 | 3,353,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,980,000.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15,149,452.89 | 13,875,662.18 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,897,496.20 | 14,476,426.52 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,900,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,900,000.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,997,496.20 | 14,476,426.52 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,997,496.20 | 14,476,426.52 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 32,761,326.86 | 19,045,395.31 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 00.00 | 00.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 32,761,326.86 | 19,045,395.31 |

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>300,655,089.40</u> | <u>349,809,100.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 23,263,449.40 | 23,772,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 23,263,449.40 | 23,772,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 23,263,449.40 | 23,772,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,357,000.00 | 23,772,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,906,449.40 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 277,391,640.00 | 326,036,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 275,324,500.00 | 295,805,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 275,324,500.00 | 295,805,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,980,000.00 | 30,231,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,980,000.00 | 30,231,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 87,140.00 | 00.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 87,140.00 | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>300,655,089.40</u> | <u>349,809,100.00</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 300,655,089.40 | 349,809,100.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 294,757,593.20 | 335,332,673.48 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 109,752,680.00 | 117,778,094.16 |
| 210101 | Үндсэн цалин | 100,619,380.00 | 80,710,106.16 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 14,332,636.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,133,300.00 | 16,380,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 6,355,352.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 12,537,966.00 | 14,174,906.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,537,966.00 | 14,174,906.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 126,225,000.00 | 126,225,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 126,225,000.00 | 126,225,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,371,497.80 | 17,514,663.32 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,509,200.00 | 2,366,919.96 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 1,591,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,449,997.80 | 1,465,963.32 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 686,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 545,300.00 | 859,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 867,000.00 | 10,545,080.04 |
| 2105 | Нормативт зардал | 418,000.00 | 1,719,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 418,000.00 | 1,719,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,210,000.00 | 13,377,930.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,210,000.00 | 13,377,930.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 497,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 497,000.00 | 00.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 32,573,000.00 | 44,543,080.00 |

Монголын уран зургийн галерейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|---------------------|----------------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,573,000.00 | 40,953,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 104,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 114,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 00.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 2,371,580.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,172,449.40 | 00.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,192,449.40 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,980,000.00 | 00.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,897,496.00 | 14,476,426.52 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,900,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,900,000.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,997,496.20 | 14,476,426.52 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,997,496.20 | 14,476,426.52 |
| 213304 | Хөрөнгийн | 00.00 | 00.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>00.00</u> | <u>00.00</u> |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>00.00</u> | <u>00.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

4.4 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|--------------------------|-----------------------|--|
| 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 859,650,551.83 | 14,314,724,236.00 | 157,810,452.75 | 15,332,185,240.58 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 859,650,551.83 | 14,314,724,236.00 | 157,810,452.75 | 15,332,185,240.58 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 32,761,326.86 | 32,761,326.86 |
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 859,650,551.83 | 14,314,724,236.00 | 190,571,779.61 | 15,364,946,567.44 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 859,650,551.83 | 14,314,724,236.00 | 190,571,779.61 | 15,364,946,567.44 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 19,045,395.31 | 19,045,395.31 |
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 859,650,551.83 | 14,314,724,236.00 | 209,617,174.92 | 15,383,991,962.75 |

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|-----------------------|---|-----------------------|-----------------------|----------------------|--------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 311,365,600.00 | 305,125,132.00 | -6,240,468.00 | 98.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 311,365,600.00 | 305,125,132.00 | -6,240,468.00 | 98.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 311,365,600.00 | 305,125,132.40 | -6,240,467.60 | 98.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 114,979,800.00 | 110,858,291.10 | -4,121,508.90 | 96.4 |
| 210101 | Үндсэн цалин | 83,141,500.00 | 79,471,455.10 | -3,670,044.90 | 95.6 |
| 210102 | Нэмэгдэл | 14,784,100.00 | 14,332,636.00 | -451,464.00 | 96.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,380,000.00 | 16,380,000.00 | 0.00 | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 674,200.00 | 674,200.00 | 0.00 | 100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 13,797,800.00 | 13,351,598.00 | -446,202.00 | 96.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,255,000.00 | 13,351,598.00 | 4,096,598.00 | 144.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,135,700.00 | 0.00 | -1,135,700.00 | 0.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 908,600.00 | 0.00 | -908,600.00 | 0.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 227,200.00 | 0.00 | -227,200.00 | 0.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,271,300.00 | 0.00 | -2,271,300.00 | 0.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 126,225,000.00 | 126,225,000.00 | 0.00 | 100.0 |
| 210304 | Байрны түрээс | 126,225,000.00 | 126,225,000.00 | 0.00 | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,672,000.00 | 8,614,663.32 | -57,336.68 | 99.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,550,000.00 | 2,366,919.96 | -183,080.04 | 92.8 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,591,100.00 | 1,591,100.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,439,700.00 | 1,465,963.32 | 26,263.32 | 101.8 |
| 210404 | Ном, хэвлэл | 686,600.00 | 686,600.00 | 0.00 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 859,000.00 | 859,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,545,600.00 | 1,645,080.04 | 99,480.04 | 106.4 |
| 2105 | Нормативт зардал | 1,810,000.00 | 1,719,000.00 | -91,000.00 | 95.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,810,000.00 | 1,719,000.00 | -91,000.00 | 95.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,210,900.00 | 5,210,000.00 | -900.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 5,210,900.00 | 5,210,000.00 | -900.00 | 100.0 |
| 2107 | Томилот, зочны зардал | 1,500,000.00 | 0.00 | -1,500,000.00 | 0.0 |
| 210702 | Дотоод албан томилот | 1,500,000.00 | 0.00 | -1,500,000.00 | 0.0 |

| | | | | | |
|---------------|--|-----------------------|-----------------------|-----------------------|--------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 39,170,100.00 | 39,146,580.00 | -23,520.00 | 99.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,560,000.00 | 35,556,500.00 | -3,500.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 104,000.00 | 104,000.00 | 0.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 114,500.00 | 114,500.00 | 0.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | | -20,000.00 | 0.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,371,600.00 | 2,371,580.00 | -20.00 | 100.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 311,365,600.00 | 305,125,132.48 | -6,240,467.52 | 98.0 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 295,805,600.00 | 281,352,632.48 | -14,452,967.52 | 95.1 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 295,805,600.00 | 281,352,632.48 | -14,452,967.52 | 95.1 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 15,560,000.00 | 23,772,500.00 | 8,212,500.00 | 152.8 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,560,000.00 | 23,772,500.00 | 8,212,500.00 | 152.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0 | 0 | 0.00 | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 13 | 13 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11 | 11 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.0 |

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл |
|-----------------------|---|------------------|----------------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 30,207,541.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 30,207,541.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 30,207,541.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 6,919,803.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 1,238,651.00 |
| 210104 | Урамшуулал | | 5,681,152.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 823,308.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 823,308.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 8,900,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 8,900,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 8,167,930.00 |
| 210604 | Урсгал засвар | | 8,167,930.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 5,396,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 5,396,500.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 30,207,541.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | | 0.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | |
| | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 30,207,541.00 |
| | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болгосон нэмэлт орлого | | 30,207,541.00 |

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|------------------------------|--------------------------------------|---|---------------------|
| Огноо: | Аудитын нэр: | Монголын уран зургийн галерейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн | Аудитын код: |
| 2019.02.15 | | | САГ-2019/12/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Монголын уран зургийн галерей | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгө н дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний | |
|------------|---|--------------|---------------------------------------|--|----------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | 1. Үзвэрийн билетийн бэлэн мөнгөний орлогыг касст бүртгэдэггүй хувь хүний гар дээр хадгалдаг. 2. Бэлэн мөнгөний тооллогоор дутагдал гарсан. | 37.5 | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | Э.Болд |
| 2 | ХХОАТ-ын тайланг буруу тайлагнасан, татварын хөнгөлөлтийг буруу тооцсон байдлыг тогтоосон | 206.7 | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | Э.Болд |
| 3 | Тооллогоор бараа материал илүүдсэн. тодруулбал үлдэгдэлтэй бараа материалыг зардалд бүртгэсэн. | 115.5 | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | Э.Болд |
| 4 | Тус байгууллага төсвийн орлого, зарлага түүний хэмнэлт хэтрэлтийг сар бүр, 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлээгүй байна. | | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | Э.Болд |
| 5 | Өөрийн үйл ажиллагааны орлого, билет, номын бэлэн мөнгөний орлогыг кассаар дамжуулахгүйгээр хурааж сард 1 удаа харилцах дансанд тушаадаг. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж тайлагнана” гэж заасныг мөрдөөгүй байна. Сар бүр дунджаар 809.3 мянган төгрөг тушаадаг. | | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | Э.Болд |
| Дүн | | 359.7 | | | |